



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 01 дүгээр сарын 02 өдөр Дугаар 01

Хэрлэн сум

I ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 01 дүгээр хуралдаан 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 16:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 72,7 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийн мэдээлэл танилцуулах,
Хүнс, хөдөө аж ахуйн газар

2.Зудын нөхцөл байдалтай сумдад ажиллах ажлын хэсэг байгуулах тухай хэлэлцэх,
Хүнс, хөдөө аж ахуйн газар

3.Зудын нөхцөл байдалд үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах тухай хэлэлцэх,
Хүнс, хөдөө аж ахуйн газар

4.Ульханмайхан, Эрэнцав хилийн боомтод дэмжлэгт хяналт хийсэн ажлын тайланг танилцуулах,
Эрүүл мэндийн газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбаяр-д:

1.1.Сумын аюулгүй нөөцийг олгосны дараа аймгийн аюулгүйн нөөцөөс өвөлжилт хүндэрсэн сумд болон өөр сумаас оторлож буй аймгийн малчин өрхөд 17,4 тн буюу 850 боодол өвс, 33,5 тн тэжээлийг хуваарилан олгох,

1.2.Өвөлжилт хүндэрсэн сумдад томилогдож ажиллах 2 ажлын хэсэгт 20 шуудай тэжээлийг аймгийн аюулгүйн нөөцөөс олгох,

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч Б.Мөнхбаяр,

Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга,
Онцгой комиссын гишүүн Г.Гарамхишиг,

 / М.Бадамсүрэн
/  / х/ч Б.Цогтбаяр

Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн захирагч,
хурандаа Н.Цэцэнхүү нарт:

2.1.Өвөлжилт хүндэрсэн Баянтүмэн, Булган, Сэргэлэн, Хөлөнбуйр, Цагаан-Овоо сумдад томилогдож ажиллах ажлын хэсгийг мэргэжлийн байгууллагын албан хаагчдын бүрэлдэхүүнтэй 2 ажлын хэсгийг байгуулж, томилон ажиллуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.2.Өвөлжилт хүндэрсэн сумдад ажиллах 2 ажлын хэсэгт шаардагдах томилолт, шатахууны зардал 2,817,500 төгрөг, хөвөнтэй бээлий 60 хосыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн сангаас ажлын хэсэгт олгох,

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга-д:

2.3."Тосон хулстай" тусгай хамгаалалттай газарт өвөлжилт хүндэрсэн сумдын малчин өрхүүдийг тодорхой хугацаагаар отроор оруулах тухай санааыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд албан бичгээр уламжлах,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,

Онцгой комиссын гишүүн А.Гантулга,

Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч Б.Мөнхбаяр,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Мөнхтөр,

Улаан загалмайн хороон дарга, Онцгой комиссын
гишүүн Б.Ганболд,

Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга,

Онцгой комиссын гишүүн Г.Гарамхишиг,

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
дарга Н.Базаррагчаа нарт:

3.1.Аймгийн зудын үнэлгээ хийх ажлын хэсгийг мэргэжлийн байгууллагын албан хаагчдын бүрэлдэхүүнтэй байгуулж, аймгийн зудын үнэлгээ хийх,

Дөрөв.Дорнод аймаг дахь Хилийн боомтын захиргааны
дарга Э.Гантулга,

Гаалын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Б.Гэрэлт-Од,

/  / М.Бадамсүрэн
/  / х/ч Б.Цогтбаяр

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа нарт:

4.1.Ульханмайхан, Эрэнцав хилийн боомтын халдваргүйжүүлэлт, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА



М.БАДАМСҮРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХОШУУЧ

Б.ЦОГТБАЯР